



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

ЦАГ АШИГЛАЛТЫН СУДАЛГАА

2 0 2 3

ХУРААНГУЙ ТАЙЛАН




ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

МОНГОЛ УЛС
ЦАГ АШИГЛАЛТЫН СУДАЛГАА 2023
Хураангуй тайлан

Хураангуй тайлан боловсруулсан
ТУНГААХУЙ ӨГӨГДЛИЙН УРЛАН

© МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО 2024

Хүн амын цаг ашиглалтыг хэмжихдээ тодорхой үйл ажиллагаанд өдөрт дунджаар хэдэн минут зарцуулж буйгаар тооцдог. Өдрийн 24 цаг нь 1440 минут болох ба, энэхүү 1440 минутыг ямар үйл ажиллагаанд, хэрхэн зарцуулж буйг тооцсон.




Үндэсний Статистикийн Хороо нь Монгол Улсын статистикийн тухай хуульд заасны дагуу 4 жил тутам Цаг ашиглалтын судалгаа (ЦАС)-г боловсруулдаг. Хуульд заасны дагуу энэ удаагийн Цаг ашиглалтын судалгааг 2023 онд зохион явуулсан ба судалгаанд 23394 өрхийг хамруулав.

Цаг ашиглалтын судалгаа нь Монгол Улсын 12 ба түүнээс дээш насны хүн амын өдөр тутмын үйл ажиллагааг хэмжиж, амьдралын хэв маягийг зурагладаг.

ЦАГ АШИГЛАЛТ, УЛСЫН ДУНДАЖ

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



| - 1 минут

1. ХҮН АМЫН АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ

Монгол хүн өдрийн 24 цагийн 51.0 хувийг зайлшгүй хувийн хэрэгцээндээ, 33.8 хувийг хөдөлмөр эрхлэхэд, 15.1 хувийг боловсрол болон чөлөөт цагтаа зарцуулж байна. Тодруулбал, 2023 оны байдлаар улсын дунджаар 12 ба түүнээс дээш насны хүн ам долоо хоногийн нэг өдрийн 12 цаг 15 минутыг унтах, хооллох, хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих гэх мэт зайлшгүй хувийн хэрэгцээнд, 4 цаг 36 минутыг хөлстэй хөдөлмөр эрхлэхэд, 3 цаг 31 минутыг хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд, 32 минутыг боловсролын үйл ажиллагаанд зарцуулж, үлдсэн 3 цаг 6 минутыг чөлөөт цагт хуваарилжээ.

Хөлсгүй хөдөлмөр эрхлэхэд зарцуулсан цаг нь хөлстэй хөдөлмөр эрхлэхэд зарцуулсан цагийн 76.4 хувьтай тэнцэхүйц буюу ийм хэмжээний хөдөлмөр эдийн засгийн хувьд ямар нэг байдлаар үнэлэгдээгүй байна.


ЦАГ АШИГЛАЛТ, УЛСЫН ДУНДАЖ

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



ЦАГ АШИГЛАЛТЫН ХУВЬСАЛ

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар



* 2011, 2015 оны ЦАС-ны үр дүнг тооцоход жин ашиглаагүй бөгөөд судалгаанд хамрагдсан хүн амын хувьд тооцсон.

ХӨЛСГҮЙ АСРАХ АЖИЛД ЗАРЦУУЛСАН ХУГАЦАА

(Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын **ерхийн гишүүдийг цалин хөлсгүй асрахад** зарцуулсан хугацаа, хүйсээр, минутаар, ЦАС явагдсан оноор)



ХӨЛСГҮЙ ГЭРИЙН АЖИЛД ЗАРЦУУЛСАН ХУГАЦАА

(Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын **гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэхэд** зарцуулсан хугацаа, хүйсээр, минутаар, ЦАС явагдсан оноор)



Монгол орны хаана амьдарч байгаагаас хамааран хүн амын цаг ашиглалт ялгаатай. Хүн амын амьдарч буй байршлаар илрэх цаг ашиглалтын хамгийн том ялгаа нь хөдөөд хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд хотынхоос илүү их цаг зарцуулдаг. Хөлстэй болон хөлсгүй нийт хөдөлмөр эрхлэлтэд хөдөөгийн хүн ам хотын хүн амаас өдөрт дунджаар 13.9 хувиар илүү цаг зарцуулдаг. Хотод ААНБ-д ажиллах зонхилсон хөлстэй хөдөлмөр давамгайлдаг бол хөдөөд мал маллах зонхилсон өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөлстэй хөдөлмөр давамгайлна. Хөдөөд МАА эрхлэх хөлстэй хөдөлмөр эрхлэлт их учраас боловсролын үйл ажиллагаа, чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаанд зарцуулах цаг хотынхоос хомс.

ЦАГ АШИГЛАЛТ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

| — 1 минут



2.

ЦАГАШИГЛАЛТ БА ХҮЙСИЙН ЯЛГАА

Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү хөдөлмөрлөдөг, гэхдээ хөлсгүй. Хөдөлмөр эрхлэлтийг хөлстэй болон хөлсгүй хөдөлмөрийн нийлбэр дүнгээр тооцвол эрэгтэйчүүд долоо хоногийн нэг өдөрт дунджаар 7 цаг 59 минутыг хөдөлмөр эрхлэлтэд зарцуулж буй бол эмэгтэйчүүд дунджаар 8 цаг 13 минутыг хөдөлмөр эрхлэхэд зарцуулж байна.

Гэхдээ илүү чухал ялгаа нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хөлстэй, хөлсгүй шинж чанараар илэрнэ. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.6 дахин их цагийг хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулдаг бол эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 2.0 дахин их цагийг хөлсгүй хөдөлмөр эрхлэхэд зориулж байна. Тодруулбал, эрэгтэйчүүдийн өдрийн дундаж хөдөлмөр эрхэлсэн цагийн 71.6 хувь нь хөлстэй хөдөлмөр бол эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхэлсэн нийт цагийн тал хүрэхгүй хувь буюу 44.6 хувь нь хөлстэй хөдөлмөрт зарцуулагджээ.

ЦАГАШИГЛАЛТ, ХҮЙСЭЭР

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023


| — 1 минут



ТХЗ "5.4.1 ЦАЛИН ХӨЛСГҮЙ ГЭРИЙН АЖИЛ, АСРАХ АЖИЛД ЗАРЦУУЛСАН ЦАГ"


Долоо хоногийн нэг өдөрт, хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 24 цагт эзлэх хувиар

Цаг ашиглалтын судалгаа нь ТХЗ-ын "5.4.1 Цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулсан цаг" үзүүлэлтийг хэмжих, хянах боломжийг олгодог. 2023 оны байдлаар эрэгтэйчүүд нэг өдрийн 24 цагийнхаа 9.0 хувийг хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулдаг бол эмэгтэйчүүд 18.5 хувийг энэ үйл ажиллагаанд зарцуулж байна.



12 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМ

Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах



15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМ

Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах

Эрэгтэй
Эмэгтэй

ТХЗ "5.4.1 ЦАЛИН ХӨЛСГҮЙ ГЭРИЙН АЖИЛ, АСРАХ АЖИЛД ЗАРЦУУЛСАН ЦАГ", УЛСААР

15 ба түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, 24 цагт эзлэх хувиар, ЦАС явагдсан оноор



НҮБ-ын ТХЗ-ын хэрэгжилтийн явцын мэдээгээр 2000-2022 оны статистикаас харахад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс өдөрт дунджаар 2.5 дахин илүү цагийг цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулж байна.* Дэлхий даяар эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү хөдөлмөрийн зах зээлд оролцох, эмэгтэйчүүд хөлсгүй хөдөлмөрийг хариуцах хандлагатай.

*https://sdgs.un.org/goals/goal5#progress_and_info

Эх сурвалж: <https://unstats.un.org/sdgs/dataportal/database>, 2024.06.28-нд шинэчлэгдсэн байдлаар

3. ЦАГ АШИГЛАЛТ БА АМЬДРАЛЫН МӨЧЛӨГ

Хүн амын амьдралын мөчлөг буюу наснаас хамааран амьдрах хэв маяг, дадал хувьсан өөрчлөгдөж байдаг. 12-17 насанд суралцах болон чөлөөт цаг, хувийн хэрэгцээний цагт хамгийн их цаг зарцуулдаг. 18-24 наснаас эхлэн боловсролд зарцуулах цаг буурч, хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд цаг зарцуулах нь нэмэгдэнэ. Хүн амын хөдөлмөр эрхлэлт 18-24 насны бүлгээс эхлэн идэвхжих ба 25-39 насанд оргил үедээ хүрч, 59 нас хүртэл идэвхтэй үргэлжилсээр 60 ба түүнээс дээш наснаас буурч эхэлдэг.


ЦАГ АШИГЛАЛТ, НАСНЫ БҮЛГЭЭР

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023




**ХӨЛСТЭЙ БОЛОН ХӨЛСГҮЙ
ХӨДӨЛМӨР ЭРХЭЛСЭН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛСАН
ХУГАЦАА, НАСНЫ БҮЛГЭЭР,
ХҮЙСЭЭР**

Долоо хоногийн нэг өдөрт 12,
түүнээс дээш насны хүн амын
дундаж цаг ашиглалт, минутаар,
2023



Хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд илрэх хүйсийн ялгаа бага наснаас буюу 12-17 наснаас эхэлж, 18 ба түүнээс дээш насанд илүү гүнзгийрдэг. Хүйсийн энэ ялгаа нь насны бүлэгт харгалзах хөдөлмөр эрхлэлтийн идэвхийг даган нэмэгдэж байна.

— 1 минут



4.

ЦАГ АШИГЛАЛТ БА ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛ


Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн ам долоо хоногийн нэг өдрийн 24 цагийн дунджаар 6.4 хувийг хөлстэй хөдөлмөрт, 13.8 хувийг хөлсгүй хөдөлмөр эрхлэхэд, 19.6 хувийг боловсрол, чөлөөт цагт, 60.2 хувийг зайлшгүй хувийн хэрэгцээндээ зарцуулж байна. **Үйлдлийн чадварын хүндрэл нь хөлстэй хөдөлмөр эрхлэх цагийг хязгаарлаж буй ч хөлсгүй хөдөлмөрийн хувьд огтхон ч хязгаарлалт болдоггүй.** Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн ам долоо хоногийн нэг өдөрт дунджаар 3 цаг 19 минутыг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байгаа нь үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амтай харьцуулахад ердөө 13 минутаар бага байна. Харин хөлстэй хөдөлмөрт зарцуулах цаг нь үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амтай харьцуулахад 3.1 дахин бага, эсрэгээрээ чөлөөт цаг нь 1.6 дахин их байна.

ЦАГ АШИГЛАЛТ, ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛТЭЙ ЭСЭХЭЭР

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

| — 1 минут






Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын хөлстэй хөдөлмөр дэх хүйсийн ялгаа өндөр. Үйлдлийн чадварын хүндрэлтэй эрэгтэй хүн үйлдлийн чадварын хүндрэлтэй эмэгтэйчүүдээс 2.9 дахин их цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байхад үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амын хувьд 1.5 дахин их цагийг зарцуулдаг.

— 1 минут

ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



ХӨЛСТЭЙ БОЛОН ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛСАН ХУГАЦАА, ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛТЭЙ ЭСЭХЭЭР, ХҮЙСЭЭР

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, минутаар, 2023

5. ЦАГ АШИГЛАЛТ БА БОЛОВСРОЛ

ЦАГ АШИГЛАЛТ, БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023




Хөдөлмөр эрхлэлтийн статус хөлстэй хөдөлмөрт шилжих нь боловсролын түвшинтэй нягт уялдаатай. Дээд боловсролтой хүн амтай харьцуулахад техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн өдөрт дунджаар 6.2 хувиар бага цагийг, бүрэн дунд боловсролтой хүн 9.4 хувиар бага цагийг, суурь боловсролтой хүн 28.0, боловсролгүй, бага боловсролтой хүн 26.4 хувиар бага цагийг тус тус хөлстэй хөдөлмөрт зарцуулж байна.

- Дээд
- Техникийн болон мэргэжлийн
- Бүрэн дунд
- Суурь
- Боловсролгүй, бага боловсролтой

Эмэгтэйчүүдийн боловсролын түвшин нэмэгдэх тусам хөлстэй хөдөлмөр дэх хүйсийн ялгаа буурдаг. Боловсролын түвшнээс үл хамааран хөдөлмөрийн хуваарьт хөлстэй хөдөлмөрийг эрэгтэйчүүд, хөлсгүй хөдөлмөрийг эмэгтэйчүүд голчлон гүйцэтгэх хандлага хэвээр. Гэхдээ боловсролгүй, бага боловсролтой хүн амын дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 2.3 дахин их цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байхад дээд боловсролтой хүн амын дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.4 дахин их цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байна.

| — 1 минут



ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨР
ЭРХЭЛСЭН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД
ЗАРЦУУЛСАН ХУГАЦАА,
БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР,
ХҮЙСЭЭР

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, минутаар, 2023

6.

ЦАГ АШИГЛАЛТ БА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хөдөлмөр эрхэлдэг байх нь хөлсгүй хөдөлмөр дэх оролцоог зогсоохгүй. Хөдөлмөр эрхэлдэг статустай 15 ба түүнээс дээш насны хүн ам хөлстэй, хөлсгүй нийт хөдөлмөрт өдөрт дунджаар 10 цаг 28 минут буюу өдрийн сэрүүн байх цагийнхаа 68.1 хувийг зарцуулдаг бол хөдөлмөр эрхэлдэггүй хүн ам 46.0 хувь буюу 6 цаг 17 минутыг зарцуулдаг. Хөдөлмөр эрхэлдэг хүн хөлстэй хөдөлмөрт их цаг зарцуулахаас гадна хөлсгүй хөдөлмөрт оролцсон хэвээр байна.


ЦАГ АШИГЛАЛТ, ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ЭСЭХЭЭР

Долоо хоногийн нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

| — 1 минут



Хөлстэй хөдөлмөр



ХӨДӨЛМӨР
ЭРХЭЛДЭГ




ХӨДӨЛМӨР
ЭРХЭЛДЭГГҮЙ


ХӨЛСТЭЙ БОЛОН ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛСАН ХУГАЦАА, ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ЭСЭХЭЭР, ХҮЙСЭЭР

Долоо хоногийн нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, минутаар, 2023

Хөлстэй хөдөлмөр



Хөлсгүй хөдөлмөр



ЦАГ АШИГЛАЛТ, ГЭРЛЭЛТИЙН БАЙДЛААР

Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

7. ЦАГ АШИГЛАЛТ БА ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ



Тусгаарласан/цуцалсан/бэлэвсэн

Гэрлэсэн - Батлуулаагүй

Гэрлэсэн - Батлуулсан


Огт гэрлээгүй

Гэрлэлтийг даган хөдөлмөр эрхлэлт, тэр дундаа хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цаг нэмэгдэж байна. Огт гэрлээгүй хүн амтай харьцуулахад гэр бүлээ батлуулсан хүн амын хөлсгүй хөдөлмөрт зарцуулсан цаг 42.1 хувиар илүү, гэр бүлээ батлуулаагүй хүн амынх 56.6 хувиар илүү, тусгаарласан, цуцалсан, бэлэвсэн хүнийх 45.3 хувиар илүү байна.

ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛСАН ХУГАЦАА, ГЭРЛЭЛТИЙН БАЙДЛААР, ХҮЙСЭЭР

Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, минутаар, 2023

Гэрлэсэн хүн амын дунд хөдөлмөр эрхлэлтийн хүйсийн ялгаа илүү гүнзгий илэрдэг. Огт гэрлээгүй эрэгтэй огт гэрлээгүй эмэгтэйгээс 1.2 дахин их цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулдаг бол гэрлэсэн эрэгтэй гэрлэлтээ батлуулсан, батлуулаагүйгээс хамааран гэрлэсэн эмэгтэйгээс 1.5-1.7 дахин их цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байна. Хөлсгүй хөдөлмөрийн хувьд хүйсийн ялгаа илүү гүнзгийрч, огт гэрлээгүй эмэгтэй огт гэрлээгүй эрэгтэйгээс 1.7 дахин их цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байхад гэрлэсэн эмэгтэй гэрлэсэн эрэгтэйгээс гэрлэлтээ батлуулсан, батлуулаагүйгээс үл хамааран 2.2 дахин их цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байна.




Хүүхэдтэй, тэр дундаа хамт амьдардаг хүүхэдтэй байх нь эрэгтэй, эмэгтэй аль аль хүйсийн хүн амын амьдралын хэв маягт өөрчлөлт авчирдаг.

18 ба түүнээс дээш насны эрэгтэйчүүдийн хувьд хамт амьдардаг 1-2 хүүхэдтэй бол огт хүүхэдгүй эрэгтэйтэй харьцуулахад хөлстэй хөдөлмөрт зарцуулах цаг нь 31.2 хувиар, эмэгтэйчүүдийн хувьд 39.4 хувиар нэмэгдэж байна.

Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цаг хамт амьдардаг 1-2 хүүхэдтэй эрэгтэйчүүдийн хувьд огт хүүхэдгүй эрэгтэйтэй харьцуулахад 14.0 хувиар, эмэгтэйчүүдийн хувьд 49.5 хувиар нэмэгдэж байна.

— 1 минут



ХҮҮХЭДГҮЙ

ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛСАН ХУГАЦАА, ХҮҮХЭДТЭЙ ЭСЭХЭЭР, ХҮЙСЭЭР

Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, минутаар, 2023


ХҮҮХЭДТЭЙ



3+ Хамт амьдарч байгаа 18 хүртэлх насны хүүхдийн тоо



1-2 Хамт амьдарч байгаа 18 хүртэлх насны хүүхдийн тоо




0 Хамт амьдарч байгаа 18 хүртэлх насны хүүхдийн тоо

8. ЦАГ АШИГЛАЛТ БА ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТҮВШИН

Өрхийн аж байдлын түвшин өндөр байх тусам хөлстэй хөдөлмөрт илүү цаг зарцуулж байна. Дунджаас доогуур аж байдлын түвшинтэй хүн ам 3 цаг 43 минут, дундаж аж байдлын түвшинтэй хүн ам 4 цаг 7 минутыг хөлстэй хөдөлмөрт өдөрт дунджаар зарцуулж байхад дунджаас дээгүүр болон дээгүүр аж байдлын түвшинтэй хүн ам 4 цаг 36-54 минутыг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байна. Харин аж байдлын түвшин хамгийн бага буюу доогуур ангилалд багтах хүн амын хувьд хандлага биелэхгүй буюу хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд бусад ангилалтай харьцуулахад хамгийн их цагийг зарцуулах хэдий ч энэ цагийнхаа дийлэнх буюу 80.4 хувийг өөрийн өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулжээ.

ЦАГ АШИГЛАЛТ, ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТҮВШНЭЭР


Долоо хоногийн нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023




ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ТҮҮНТЭЙ ХОЛБОГДОХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛСАН ХУГАЦАА, ӨРХИЙН АЖ
БАЙДЛЫН ТҮВШНЭЭР, ХҮЙСЭЭР

Долоо хоногийн нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын
дундаж цаг ашиглалт, минутаар, 2023


ДООГУУР




ДУНДЖААС
ДООГУУР




ДУНДАЖ



ДУНДЖААС
ДЭЭГҮҮР



ДЭЭГҮҮР



Хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цагт илрэх хүйсийн ялгаа аж байдлын түвшин үл харгалзан ажиглагдах боловч аж байдлын түвшин ахих тусам хөлстэй хөдөлмөр дэх эрэгтэйчүүд давамгайлсан хүйсийн ялгаа буурч байна. Харин хөлсгүй хөдөлмөр дэх эмэгтэйчүүд давамгайлсан хүйсийн ялгаа дунджаас доогуур, дундаж, дунджаас дээгүүр түвшинд аж байдлын түвшин сайжрахын хэрээр буурах боловч дээгүүр түвшний аж байдалтай хүн амын хувьд хөлсгүй хөдөлмөрт эмэгтэйчүүд илүү цаг зарцуулах хүйсийн ялгаа нэмэгдэж байна.

